Толгойн анхдагч өвдөлтийн зарим дарамтыг судалсан нь

Д.Болорцэцэг[1,2], Л.Отгонбаяр[1], Л.Ундрам[1]

[1]Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
[2]Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг
Цахим шуудан: undram.l@mnums.edu.mn, Утас: 99094087

Түлхүүр үг:

Анхдагч толгой өвдөлт
Өвчний дарамт
Бүтээмжит хоногийн алдагдал

Товч утга:

Үндэслэл: Хүн амын дунд хамгийн түгээмэл тохиолдох, амьдралын турш олон давтагддаг эмгэг бол толгой өвдөлт юм. Анхдагч толгой өвдөлт нь хувь хүний амьдралд сөргөөр нөлөөлж, дарамтыг үүсгэж байгаа нь олон судалгаануудаар батлагддаг. **Зорилго:** Толгойн анхдагч өвдөлтийн улмаас үүсэх зарим дарамтыг судлах. **Арга, аргачлал:** Өвчний дарамтыг тодорхойлохдоо давтамж, өвдөлтийн хүч, үргэлжлэх хугацааг толгой өвдөлтийн хэлбэр тус бүрээр, хүйсээр үнэлсэн. Толгой өвдөлтийн улмаас үүсэх чадавхи алдагдлыг тодорхойлохдоо толгой өвдөлтийн хэлбэр тус бүрээр тооцоолон гаргасан. Эдийн засгийн хохиролыг хэвтэн эмчлүүлсэн хөдөлмөрийн насны хүний тоо, нэг өдрийн дундаж цалин (төгрөг) ба толгойн анхдагч өвдөлт оноштойгоор эмчлүүлж буй дундаж хоногоор үржүүлж тооцсон. **Үр дүн:** Агшингийн судалгаанд 150 хүн хамрагдсанаас хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт 59% эзэлж байсан бол эмийн хэт хэрэглээтэй холбоотой байж болзошгүй хэлбэр 13.8% байгаа нь өндөр үзүүлэлт байна. Толгой өвдөлтийн сарын дундаж давтамж 6.4 өдөр/сар, толгой өвдөлтийн дундаж хүч 2.5 байсан байна. Бие хүнд үзүүлэх шинж тэмдэгийн дарамт бүх үзүүлэлтээр мигрень болон Эмийн хэт хэрэглээтэй холбоотой үүссэн толгой өвдөлт (ЭХХХТӨ) нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна (p=0.001). Мигрений сэдрэлийн эзлэх хувь нь мигрений нийт үргэлжилсэн хугацааны 12.5% байна. Толгой өвдөлтийн дарамтын дараагийн нэг үзүүлэлт бол бүтээмжит хоногийн алдагдал бөгөөд бүх хэлбэрийн толгой өвдөлтийн үед эмэгтэйчүүдэд чадвар алдалт илүү, түүн дотроос гэрийн ажлын алдагдсан өдрийн тоо нь эрэгтэйчүүдээс их байна (p=0.043). Толгой өвдөлтийн улмаас бүтээмжит цагийн алдагдал мигрений үед 4.2% бусад хэлбэрүүдээс хамгийн өндөр байна. Толгой өвдөлтийн улмаас хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн ХЧТА-аас үүдэлтэй эдийн засгийн хохирол 6 сая 600 мянган төгрөг гарсан.

Үндэслэл: Толгой өвдөлт нь хамгийн өргөн тархсан эмгэг юм. Дэлхий нийтийн насанд хүрэгчдийн 50 орчим хувь нь сүүлийн нэг жилд толгой өвдсөн гэсэн өгүүлэмжтэй байсан бол[7] эдгээрийн 30 орчим хувь нь сэдрэлтэт мигреньтэй, 1.7- 4% нь архаг толгой өвдөлттэй байсан байна.[7] Газар зүйн байршил, нас, арьс өнгө, орлогын түвшинг үл харгалзан толгой өвдөлт нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал хэвээр байна.[3] 2017 оны дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох судалгаагаар мигрень нь хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэг эмгэгүүдийн жагсаалтын 6 дугаар байранд, эмийн хэт хэрэглээтэй холбоотой үүсэх толгойн өвдөлт нь жагсаалтын 18-р байранд, нийлбэр дүнгээр толгой өвдөлт дээрх жагсаалтын 3 дугаарт эрэмбэлэгдэж байна.[4] Европын орнуудад толгой өвдөлтийн эмчилгээний дундаж зардал жил тутам (мигрень 1222 евро, хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт 303 евро) ихсэж байгаа тухай мэдээлжээ.[5] Толгойн анхдагч өвдөлтийн тархалд, дарамтыг тодорхойлох зорилгоор Олон улсын толгой өвдөлтийн нийгэмлэг, ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн HARDSHIP асуумжаар улс орнуудад толгой өвдөлтийн тархалтын болон дарамтын судалгаа хийсэн.[6] Турк улсад хийгдсэн судалгаанд толгой өвдөлтийн улмаас

бүтээмжит хоногийн алдагдлыг үнэлэхэд толгой өвдөлттэй холбоотой ажлын бүтээмж 39.6 хувиар буурдаг болохыг нотолжээ.[7] Америк, Англи, Турк улсуудад хийсэн мигрений улмаас бүтээмжит хоногийн алдагдлыг тооцох судалгаанд ажил болон сургуулиас алдагдсан өдрүүдээс, гэрийн ажил алдагдсан өдрүүд их байсан байна.[8] Непалд ажил, гэрийн ажил болон нийгмийн үйл ажиллагаанаас алдагдсан хоног нь эмийн хамааралт байж болзошгүй толгой өвдөлтийн үед мигренээс илүү, хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлтөөс 2 дахин илүү байсан байна.[9] Манай улсад толгойн анхдагч өвдөлтийн тархалт харьцангуй өндөр байгаа боловч дарамтыг тодорхойлсон судалгаа одоогоор хийгдээгүй байна.

Зорилго: Толгойн анхдагч өвдөлтийн улмаас үүсэх зарим дарамтыг судлах

Зорилт:

1. Толгойн анхдагч өвдөлтийн улмаас үүсэх бие хүнд учрах дарамт болон бүтээмжит цагийн алдагдлыг тооцох
2. Толгойн анхдагч өвдөлтийн үед үүсэх үйл ажиллагааны алдагдалаас үүдэлтэй эдийн засгийн хохирлыг тооцох

Арга, аргачлал: Агшингийн судалгааны загварыг ашиглан Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн мэдрэлийн кабинетаар үзүүлсэн болон хэвтэн эмчлүүлэгсдээс ICHD-III ангиллын дагуу толгойн анхдагч өвдөлт оношлогдсон 150 хүнээс асуумжийн аргаар мэдээлэл цуглуулж авлаа.

Бид бие хүнд үзүүлэх өвчний дарамтыг тодорхойлохдоо давтамж (өдөр/сар), өвдөлтийн хүч (бага-1, дунд-2, хүчтэй-3), үргэлжлэх хугацааг толгой өвдөлтийн хэлбэр тус бүрээр, хүйсээр үнэлсэн. Толгой өвдөлтийн улмаас үүсэх чадавхи алдагдлыг тодорхойлохдоо толгой өвдөлтийн хэлбэр тус бүрээр (мигрень, хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт, эмийн хэт хэрэглээтэй холбоотой үүссэн толгойн өвдөлт) тооцоолон гаргасан. Сэдрэлийн үеийг тооцохдоо толгой өвдөлтийн давтамж болон үргэлжлэх хугацааг, нийт хугацаанд пропорционалиар хувааж тооцоолсон. Толгой өвдөлтийн улмаас хувь хүнд үүсэх чадавхи алдалтыг (mean disability per person with headache) сэдрэлийн үе болон Дэлхийн өвчний дарамт 2017 чадавхи алдалтын үнэлгээгээр тооцсон.

Толгой өвдөлтийн улмаас бүтээмжит хоногийн алдагдлыг сүүлийн 3 сарын хугацаанд толгой өвдөлтийн улмаас цалинтай ажилдаа (хичээл) явж чадаагүй өдөр, цалинтай ажлаа (хичээл) дутуу хийсэн өдөр, гэрийн ажлаа хийж чадаагүй өдөр, гэрийн ажлаа дутуу хийсэн өдөр, нийгмийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй өдрүүдийг харгалзан тооцсон. Алдагдсан хоногийн тоог толгой өвдөлтийн хэлбэр, давтамж бүрээр үнэлсэн ба I-IV зэргээр тооцсон. Шат ахих тусам эмнэлгийн тусламж илүү хэрэгтэй болно. III, IV зэрэг нь өндөр шаардлагатай байгааг харуулдаг.

Үйл ажиллагааны алдагдлаас гарах эдийн засгийн хохиролыг үйл ажиллагааны алдагдлын ажлын өдрийн тоо, хөдөлмөрийн бүтээмж, үйл ажиллагаа алдсан тохиолдлын үзүүлэлт үйл ажиллагааны алдагдлын тохиолдолд ногдох хоногийн тоо зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолох тэгшитгэл зэрэг аргыг ашигласан.

Үйл ажиллагааны алдагдлаас үүсэх эдийн засгийн хохирол=хэвтэн эмчлүүлсэн хөдөлмөрийн насны хүний тоо*нэг өдрийн дундаж цалин (төгрөг)*толгойн анхдагч өвдөлт оноштойгоор эмчлүүлж буй дундаж хоног гэсэн аргачлалаар тооцсон.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 18-65 настай нийт 150 хүний 88 (58.6%) эмэгтэй, 62 (41.3%) эрэгтэй, дундаж нас 37.5±7.5 байна.

Бие хүнд үзүүлэх өвчний дарамт буюу толгой өвдөлтийн давтамж, хүч, үргэлжлэх хугацааг толгой өвдөлтийн хэлбэр болон хүйсээр харуулав (Хүснэгт 1). Толгой өвдөлтийн сарын дундаж давтамж 6.4 өдөр/сар байсан. Толгой өвдөлтийн хэлбэрээр эмийн хэт хэрэглээтэй холбоотой үүссэн толгой өвдөлт хамгийн өндөр давтамжтай (p=0.001) байна. Толгой өвдөлтийн хүчийг 1-3 оноогоор (бага-1, дунд-2, хүчтэй-3) үнэлэхэд нийт судалгаанд оролцогсдын толгой өвдөлтийн хүчийн дундаж 2.5 байна. Нийт оролцогсдын дийлэнхид толгой өвдөлт хүчтэй (n=78; 52%) болон дунд (n=69; 46%) зэргийн өвдөлт өгч байжээ. Толгой өвдөлтийн 1 сарын дотор сэдрэлийн үргэлжлэх хугацаа мигрений үед (45.7±7.7цаг), хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлтөөс (20.6±3.0 цаг) илэрхий илүү байна (p=0.0002). Бүх хэлбэрийн толгой өвдөлтөд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү их өртсөн байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1. Хувь хүнд үзүүлэх өвчний шинж тэмдэгийн дарамт

Үзүүлэлт	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	P утга
Нийт толгой өвдөлт (N=150 [эрэгтэй=62, эмэгтэй=88])				
Толгой өвдөлтийн давтамж (өдөр/сар)				
Голч [Квартил$_{1,3}$]	1.8 [0.7-2.0]	1 [0.5-1]	2 [0.4-2]	0.32
Толгой өвдөлтийн хүч				
Бага	3 (2)		3 (2.5)	
Дунд	59 (46)	5 (50.0)	54 (45.0)	
Хүчтэй	68 (52)	5 (50.0)	63 (52.5)	
Дундаж±СХ	2.5±0.54	2.5±0.52	2.5±0.55	
Толгой өвдөлтийн үргэлжлэх хугацаа (цаг)				
Голч [Квартил$_{1,3}$]	24 [2-24]	24 [2-24]	24 [2-24]	0.91
Мигрень (N=40 [эрэгтэй=13;эмэгтэй=27])				
Толгой өвдөлтийн давтамжаар (өдөр/сар)				
Голч [Квартил$_{1,3}$]	2.0[0.5-2]	1.8[0.4-1]	2.0 [0.5-2]	0.0008
Толгой өвдөлтийн хүч				
Бага				
Дунд	7 (17.5)	5 (50.0)	6 (17.6)	
Хүчтэй	33 (82.5)	1 (100.0)	28 (82.3)	
Дундаж±СХ	2.5±0.54	3	2.8±0.06	0.42
Толгой өвдөлтийн үргэлжлэх хугацаа (цаг)				
Голч [Квартил$_{1,3}$]	24 [12-72]	24 [24-24]	24 [11.5-72]	0.0002
Хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт (N=109 [эрэгтэй=40;эмэгтэй=69])				
Толгой өвдөлтийн давтамжаар (өдөр/сар)				
Голч [Квартил$_{1,3}$]	1.8 [4-7]	1 [0.5-1]	2 [0.7-1.7]	
Толгой өвдөлтийн хүч				
Бага	4 (3.6)		3 (3.4)	
Дунд	61 (55.9)	5 (55.5)	44 (55.8)	
Хүчтэй	44 (40.3)	4 (44.4)	35 (40.7)	
Дундаж±СХ	2.5±0.54	2.4±0.17	2.3±0.05	
Толгой өвдөлтийн үргэлжлэх хугацаа (цаг)				
Голч [Квартил$_{1,3}$]	24 [2-24]	24 [2-24]	14.5 [1.8-24]	0.0002
Дундаж±СХ	26±8.5	22.4±7.6	27.0±9.4	0.001
ЭХХҮТӨ (N=21 [эрэгтэй=6 ;эмэгтэй=15])				
Толгой өвдөлтийн давтамжаар (өдөр/сар)				
Толгой өвдөлтийн хүч				
Голч [Квартил$_{1,3}$]	1.8 [4-7]	1 [0.5-1]	2 [0.7-1.7]	
Бага			2 (100)	
Дунд	7 (33.3)	2 (17.3)	21 (82.6)	
Хүчтэй	14 (66.6)	5 (20.6)	24 (79.3)	
Дундаж±СХ	2.6±0.51	2.0±0	2.8±0.4	0.45
Толгой өвдөлтийн үргэлжлэх хугацаа (цаг)				
Голч [Квартил$_{1,3}$]	24 [2-24]	3 [3-3]	24.0 [12.5-36]	0.76

Сүүлийн гурван сарын хугацаанд бүтээмжит хоногийн алдагдалыг толгой өвдөлтийн хэлбэр бүрээр харьцуулан судлахад нийт алдагдсан хоногийн нийлбэрээр (ажлын алдагдсан хоног, гэрийн ажлын ажлын алдагдсан хоног, нийгмийн идэвхи алдагдсан хоног) мигрений улмаас алдагдсан цаг хугацаа хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлтийнхээс 2 дахин их байна (p=0.001). Цалинтай ажлын болон гэрийн ажлын алдагдсан өдрийн тоо нь толгой өвдөлтийн хэлбэрээс хамаарахгүй байна. Харин эмэгтэйчүүдэд гэрийн ажил алдагдсан өдрийн тоо (8.5±9.9 өдөр) эрэгтэйчүүдээс (2.7±2.9 өдөр) их байна (p=0.043) (Хүснэгт 2).

Бүх хэлбэрийн толгой өвдөлтийн үед ажлын алдагдсан өдрийн дундаж хоног (сүүлийн 3 сард 2.7 өдөр), ба нийт оролцогчдын 96% толгой өвдөлт ажил амьдралд нь нөлөөлсөн гэсэн байна. Сүүлийн 3 сарын ажлын хоног 21*3, ажлын хоногийн алдагдалыг тооцон

үзвэл 4.2% байна. Мигрений үеийн ажлын хоногийн алдагдал 4.0% байгаа нь бусад толгой өвдөлтийн дундажаас өндөр байна. Сүүлийн 3 сарын ажлын бүтээмжийн бууралт 63% байна. Олон нийтийн ажлаас алдагдсан хоногийн тоо нь толгой өвдөлтийн хэлбэрээс хамаарч мигреньтэй хүмүүст хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлтөөс илэрхий илүү байна (p=0.0047).

Хүснэгт 2. Бүтээмжит хоногийн алдагдал ба толгой өвдөлтийн хэлбэрийн хамаарал

Үзүүлэлт	Нийт алдагдсан өдөр	Цалинтай ажлын алдагдсан өдөр	Гэрийн ажлын алдагдсан өдөр	Нийгмийн идэвхи алдагдсан өдөр
	Голч [Q_1, Q_3]	Голч [Q_1, Q_3]	Голч [Q_1, Q_3]	Голч [Q_1, Q_3]
ТӨ Бүх хэлбэрүүд				
Нийт	20 [9-40.25]	7 [10-4]	5 [2-10]	12 [17-3]
Эрэгтэй	5 [0-18.5]	6 [8-2.25]	2.5 [0-5]	4 [7-0.25]
Эмэгтэй	20.5 [10-42]	11 [2-5]	6 [2.25-10]	6 [10-3]
p утга	0.04	0.21	0.043	0.0047
Мигрень				
Нийт	29 [17-77]	1 [0-5]	7 [5-10]	2 [0-6]
Эрэгтэй	5 [5-5]	2 [1-5]	2 [0-5]	2 [0-4]
Эмэгтэй	29.5 [17.7-77]	1.5 [0-5.2]	7 [5-10.5]	2 [0-7]
p утга	0.001	0.059		
Хүчдэлийн ХШТӨ				
Нийт	17 [8-32]	0 [0-3]	5 [2-10]	0 [0-2]
Эрэгтэй	5 [0-19]	0 [0-2.5]	5 [0-5]	0 [0-0.5]
Эмэгтэй	18.5 [8-35]	0 [0-3.25]	5 [2-10]	0 [0-2]
p утга	1			
ЭХХХТӨ				
Нийт	29 [17-77]	18 [2-18.3]	8.5 [3.7-15.5]	13 [4-27]
Эрэгтэй	5 [5-5]	4 [2-11]	3 [1-7.5]	3 [1-8]
Эмэгтэй	29.5 [17.7-77]	1.5 [0-5.2]	7 [5-10.5]	2 [0-7]
p утга	0.001	0.059		

Толгой өвдөлтийн улмаас өдөр тутмын үйл ажиллагааны алдагдалтай холбоотой эдийн засгийн хохирол**:** Нийт зардлыг мигрень, хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт, эмийн хэт хэрэглээтэй холбоотой толгой өвдөлт (4’640’200 төгрөг; 8’769’600 төгрөг; 4’031’000 төгрөг) харьцуулан гаргав. Толгой өвдөлтийн улмаас үүссэн шууд бус зардлын хэлбэрүүдийг нийт хэмжээг толгой өвдөлтийн хэлбэрээр болон үргэлжлэх хугацаагаар тус бүрт нь харьцуулан үзэхэд өвчин намдаагч эмийн зардал (сүүлийн 1 сар) эмийн хэт хэрэглээтэй холбоотой толгой өвдөлтөнд (p=0.045) статистик ач холбогдол бүхий илүү байв.

Хүснэгт 3. Толгойн өвдөлттэй холбоотой шууд зардал (төгрөгөөр)

Зардлын төрлүүд	Нийт	Мигрень	ХХШТЭ	ЭХХХҮТӨ	p утга
Эмнэлэгт хэвтсэн нийт зардал	2’186’600	627’600	1’559’000	0	
Өвчин намдаагч эмийн зардал	1’112’300	375’700	736’600	568’000	0.045
Урьдчилан сэргийлж уусан эмийн зардал	1’257’800	332’900	924’900	124’000	0.51
Үзлэг\зөвлөгөө	2’114’800	1’250’000	864’800	1’250’000	0.67
Шинжилгээ/Оношилгооны зардал	5’195’000	1’789’000	3’406’000	2’089’000	0.73
Тээврийн хэрэгслийн зардал	75’300	15’000	60’300	0	
Эргэлтийн зардал	1’468’000	250’000	1’218’000	0	
Нийт	13’409’800	4’640’200	8’769’600	4’031’000	

Монгол улсын Статистикийн Үндэсний хорооноос гаргасан тайланд 2019 оны улсын дундаж хөдөлмөрийн хөлсний хэмжээ 1’200’000 төгрөг байсан. Бидний судалгаанд хамрагдсан 150 хүнээс анхдагч толгой өвдөлтийн улмаас хөдөлмөрийн насны 22 хүн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд дундаж ор хоног нь 7.0-7.5 байв. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэнтэй холбоотой гарсан шууд бус зардал нь 6’600’00 төгрөг байв.

Хэлцэмж: Толгой өвдөлт нь хүн амын дунд түгээмэл тархсан, өрхийн эмч болон мэдрэлийн эмчид хандаж буй шалтгааны эхний эгнээнд байдаг зовуурь юм. Монгол улсад 2018 онд хийсэн анхдагч толгой өвдөлтийн тархалтын судалгаанд, архаг явцтай,

хүчтэй өвдөлтийн улмаас хөдөлмөрийн чадвар, амьдралын чанарт нөлөөлдөг мигрень (23,1%) болон эмийн хэт хэрэглээтэй холбоотой толгой өвдөлтийн (5.7%) тархалт дэлхийн дунджаас өндөр байсан.[10] Бидний агшингийн судалгаанд 150 хүн хамрагдсанаас хүчдэлийн хэв шинжит толгой өвдөлт 59% эзэлж байсан бол эмийн хэт хэрэглээтэй холбоотой байж болзошгүй хэлбэр 13.8% байгаа нь мөн өндөр үзүүлэлт байна. Явцын хувьд толгой өвдөлттэй хүмүүсийн 42.7% нь архаг буюу сард 15-с илүү хоногоор толгой өвддөг байгаа нь анхаарал татаж байна.

Бидний судалгааны дүнгээс харахад шинж тэмдэгийн буюу толгой өвдөлтийн дарамт нь эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү нөлөөлж, бүх үзүүлэлтээр мигрень болон ЭХХХТӨ нь хамгийн өндөр өвчний дарамтыг үзүүлж байна. Толгойн анхдагч өвдөлтийн хэлбэрүүдээс хүний амьдралын идэвхи, хөдөлмөрийн чадвар зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд хамгийн их сөрөг нөлөөтэй нь мигрень болохыг судлаачид тогтоосон байдаг. Мигрений сэдрэлийн эзлэх хувь нь мигрений нийт үргэлжилсэн хугацааны 12.5% байгаа нь бусад орны судлаачдынхаас өндөр байна, тухайлбал энэ үзүүлэлт Непалд 5.4%, Энэтхэгт 4.2 % байсан байна. Мигрений улмаас үүсэх дарамт өвдөлтийн үргэлжлэх хугацаа, хөдөлмөрийн чадвар түр алдалт нь бусад толгой өвдөлтөөс илүү байгаа нь 2014 онд Европын орнуудад хийсэн Migraine Voice, Этиоп, Непал улсад хийгдсэн судалгаануудтай адил үр дүнтэй байна.[11] Толгой өвдөлтийн дарамтын дараагийн нэг үзүүлэлт бол бүтээмжит хоногийн алдагдал юм. Энэ үзүүлэлтээр судлаачид толгой өвдөлтийн дарамтыг олонтаа судалсан байдаг. Бүх хэлбэрийн толгой өвдөлтийн үед эмэгтэйчүүд чадвар алдалт илүү байдаг бөгөөд бүтээмжит хоногийн алдагдал, түүн дотор дотор гэрийн ажлын алдагдсан өдрийн тоо нь эрэгтэйчүүдээс их байна (p=0.043). Толгой өвдөлтийн улмаас бүтээмжит цагийн алдагдал мигрений үед 4.2% бусад хэлбэрүүдээс өндөр байна. Уг үзүүлэлтийг бусад орныхтой харьцуулахад Непалд 8.3%, Энэтхэгт 5.8%, Филиппинд сүүлийн 3 сард дунджаар 9 хоног буюу нийт ажлын цагийн 10% алдагдаж байгаа гэсэн үзүүлэлтээс харьцангуй бага байна. Энэ нь манай судалгаанд хамрагсад толгой өвдөж байсан хэдий ч ажлаа үргэлжлүүлэн хийдэг, ажилдаа ирдэгтэй холбоотой байх магадлалтай юм.

Бидний судалгаанд цалинтай ажлаас алдагдсан хоногийн тоо нь хүйсийн хувьд хамааралгүй байгаа нь манай оронд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт өндөр байдагтай холбоотой байх талтай, харин Непалд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт маш доогуур байдаг тул энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд өндөр гарсан байна. Бидний судалгаанд бусад орнуудтай нэгэн адилаар эмэгтэйчүүдэд гэрийн ажлын алдагдсан хоног эрэгтэйчүүдээс их байгаа нь уламжлалт үзэл аль ч оронд хэвээр байдаг гэдгийг харуулж байна. Толгой өвдөлтийн улмаас хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийн ХЧТА-аас үүдэлтэй эдийн засгийн хохирол 6 сая 600 мянган төгрөг гарсан байгаа нь, Андрей Негро нарын Италид[12] (2037 евро) хийсэн судалгаатай ойролцоо, Жозеф Дарба нарын Испанид[13] (2800 евро) хийсэн судалгаанаас бага байна. Гэвч манай орны эдийн засгийн хөгжлийн түвшин бага, бага дунд орлоготой хөгжиж буй орны хувьд (дотоодын нийт бүтээгдэхүүн Итали 1848 доллар тэрбум, Испани 1280 доллар тэрбум, Монгол 13 тэрбум доллар) энэ нь өндөр үзүүлэлт юм. Непал, Этиоп, Гүрж зэрэг улсуудад хийсэн судалгаанууд ойролцоо үзүүлэлттэй байсан ба толгойн анхдагч өвдөлтийн менежментийг сайжруулах шаардлагатай тухай дурджээ.

Дүгнэлт:

1. Толгойн анхдагч өвдөлт, ялангуяа архаг явцтай мигрень болон эмийн хэт хэрэглээтэй холбоотой толгой өвдөлт нь хувь хүнд дарамттай, хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэг эмгэг юм.
2. Толгойн анхдагч өвдөлт нь хувь хүнийг чадвар алдалтанд хүргэж эдийн засгийн хохирлыг үүсгэж байна.

Ном зүй:

1. *Г.Цагаанхүү "Мэдрэл судлал" ном. 2019; 240-242.*
2. *Third edition of the International Classification of Headache Disorders (ICHD-3).https://ichd-3.org/*
3. *Stovner LJ, Andree C Prevalence of headache in Europe: a review for the Eurolight project. J Headache Pain 2010;1.*
4. *Steiner TJ, Stovner LJ, Vos T, et al. Migraine is first cause of disability in under 50S: will health politicians now take notice? J Headache Pain 2018;19:17*
5. *Steiner TJ, Stovner LJ, Dua T, Birbeck GL, Jensen R, Katsarava Z, Martelletti P, Saxena S. Time to act on headache disorders. J Headache Pain. 2011;12:501–503. doi: 10.1007/s10194-011-0368-7*
6. *Stewart, Walter F; Lipton, Richard B; Kolodner, Kenneth B.; Sawyer, James; Lee, Clara; Liberman, Joshua NValidity of the Migraine Disability Assessment (MIDAS) score in comparison to a diary-based measure in a population sample of migraine sufferers. Pain: October 2000 - Volume 88 - Issue 1 - p 41-52.doi: 10.1016/S0304-3959(00)00305-5.*
7. *Stewart WF, Lipton RB, Kolodner K, Sawyer J, Lee C, Liberman JN (2000) Validity of the migraine disability assessment (MIDAS) score in comparison to a diary-based measure in a population sample of migraine sufferers. Pain 88:41–52.*
8. *Linde M, Steiner TJ, **Chisholm D** Cost-effectiveness analysis of interventions for migraine in four low- and middle-income countries. J Headache Pain. 2015 Feb 18;16:15. doi: 10.1186/s10194-015-0496-6.*
9. *Kedar Manandhar, Ajay Risal, Mattias Linde&Timothy J. SteinerThe burden of headache disorders in Nepal: estimates from a population-based survey The Journal of Headache and Painvolume **17**, Article number: 3 (2015).*
10. *Л.Отгонбаяр, Ц.Бямбасүрэн, Э.Сэлэнгэ, Б.Доржханд, П.Дэлгэрмаа,Timothy J. Steiner Монгол улсын насанд хүрсэн хүн амын дундах толгойн архаг өвдөлтийн тархалт, эмнэлзүйн зарим асуудалд.(2018) Мэдрэл судлалын Монголын сэтгүүл 2018: 21-27.*
11. *Stovner LJ, Hagen K, Jensen R, Katsarava Z, Lipton R, Scher A, Steiner T, Zwart JA (2007) The global burden of headache: a documentation of headache prevalence and disability worldwide. Cephalalgia 27:193–210, 17381554, 10.1111/j.1468-2982.2007.01288.x.*
12. *Andrea Negro, Paolo Sciattella, Daniele Rossi, Martina Guglielmetti, Paolo Martelletti,Francesco Saverio Mennini (2019) Cost of chronic and episodic migraine patients in continuous treatment for two years in a tertiary level headache Centre. J Headache Pain. 2019 20:120*
13. *Josef Darba, Alicia Marsa, Analysis of the management and costs of headache disorders in Spain during the period 2011–2016: a retrospective multicentre observational study (2020) BMJ Open 10:034926.doi:10.1136.*

Study on some burden of primary headaches

Bolortsetseg D[1,2], Otgonbayar L[1], Undram L[1]

[1]Mongolian National University of Medical Sciences
[2]General Hospital for State Special Servants
E-mail: undram.l@mnums.edu.mn, Tel: 99094087

Background: Headaches are the most common and chronic condition in the population. Numerous studies have shown that primary headaches can affect a person's life and cause stress.
Aim: to study some burden of primary headaches.
Materials and Methods: The burden was assessed by the frequency, severity and duration of headache by each type of headache and by sex. Capacity loss due to headache was calculated for each type of headache. Economic loss was calculated multiplying number of individuals with headache by daily average wage and average of bed days.
Results: Some 150 individuals were recruited to the cross-sectional study. 59% were people with tension-type headache and 13.8% of participants were medication-overuse headache. Average frequency of headache was 6.4 days per month, severity was in average 2.5. Functional burden was mostly from medication-overuse headache and migraine (p=0.001). Migraine's ictal state was 12.5% of total attack duration. According to our estimate, women were more prone to the headache attributed lost time, especially at activities at home (p=0.043). The migraine attributed lost time index was 4.2%, higher than other primary headache. Economic burden from productivity loss was 6 million 600 thousand MNT for last three months.
Conclusion: Primary headache, especially migraine and medication-overuse headaches, cause significant burden such as economic and productivity loss.

Keywords: primary headache, disease burden, headache attributed lost time